



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/110

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2022 оны 03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын шуурхай штабын оператив бүлгийг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Эрүүл мэндийн газрыг түшиглэн байгуулж үйл зохион байгуулсугай.

2. Шуурхай штабын оператив бүлгийн хуваарийг гарган батлуулж, байрлан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангуулж, коронавирус (КОВИД-19)-ын халдвар болон бусад эрүүл мэндийн өвчлөлийн үед шуурхай штабын даргыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтагтөгс), аюулт үзэгдэл, ослын үед шуурхай штабын даргыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Шуурхай штабын дарга (М.Анхбаяр)-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4822100260